

Олон Талт Хэрэглүүр (ОТХ)-ийн дагуу 2025 оноос

Давхар татварын гэрээнд орох өөрчлөлтүүд




1. Олон Талт Хэрэглүүр (ОТХ) ба Монгол Улс дахь хэрэгжилт

Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх (ТСБАШ) явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Олон Талт Конвенц гэсэн албан ёсны нэртэй ОТХ нь ТСБАШ-ийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх тухайн улсын татварын бодлогод нийцүүлэн татварын гэрээнд өөрчлөлт оруулах уян хатан хэрэгсэл юм.

Тодруулбал, ОТХ нь Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-аас боловсруулсан олон улсын гэрээ юм.

Монгол Улс (цаашид "МУ") ОТХ-д нэгдэн орсноос эхлэн хүчин төгөлдөр болох 2025 оны 1-р сарын 1-ний өдрийг хүртэл хийгдсэн гэрээг баталгаажуулалтын цаг хугацааны процессийг харуулбал:



Энэхүү Татварын мэдээллээр ОТХ-д багтсан заалтууд, хувилбаруудаас МУ-ын сонгосон байр суурь болон тэдгээрийн давхар татварын гэрээний хэрэглээнд үзүүлэх үр нөлөөний талаар товч танилцуулга өгөхийг зорилоо. Монгол Улс ОТХ-д нэгдсэн тухай манай татварын өмнөх мэдээллийг [энд дарж](#) үзнэ үү.



2. Монгол Улсын давхар татварын гэрээнүүд ОТХ-ийн хүрээнд өөрчлөгдөнө

МУ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх давхар татварын гэрээ (ДТГ)-нүүдээ ОТХ-ийн Хамрагдах Татварын Гэрээ (ХТГ)-ний жагсаалтад оруулсан байна. Гэвч зарим ДТГ-ний Хэлэлцэн тохирогч нөгөө улсууд ОТХ-д хараахан нэгдээгүй эсвэл өөрсдийн ОТХ-ийн ХТГ-ний жагсаалтад МУ-тай байгуулсан ДТГ-ийг оруулаагүй байна. Үүний үр дүнд, доорх хүснэгтэд тодруулсан МУ-ын **19 ДТГ** 2025 оноос эхлэн ОТХ-ийн хүрээнд өөрчлөгдөхөөр байна.

№	Улсын нэр	MLI нэгдэн орсон огноо	MLI хүчин төгөлдөр болсон огноо	МУ-ын ДТГ-г оруулсан эсэх
1	Австри	2017.06.07	2018.07.01	Тийм
2	Беларусь	Нэгдээгүй	N/A	N/A
3	Бельги	2017.06.07	2019.06.26	Тийм
4	Болгар	2017.06.07	2019.06.26	Тийм
5	Канад	2017.06.07	2019.08.29	Тийм
6	Хятад	2017.06.07	2022.09.01	Тийм
7	Чех	2017.06.07	2020.09.01	Тийм
8	Франц	2017.06.07	2019.01.01	Тийм
9	Герман	2017.06.07	2021.01.07	Үгүй
10	Унгар	2017.06.07	2021.03.25	Үгүй
11	Энэтхэг	2017.06.07	2021.01.10	Тийм
12	Индонез	2017.06.07	2020.04.28	Тийм
13	Итали	2017.06.07	2020.04.28	Тийм

№	Улсын нэр	MLI нэгдэн орсон огноо	MLI хүчин төгөлдөр болсон огноо	МУ-ын ДТГ-г оруулсан эсэх
14	Казахстан	2018.06.25	2020.10.01	Тийм
15	Киргиз	Нэгдээгүй	N/A	N/A
16	Малайз	2018.01.24	2021.02.18	Тийм
17	Хойд Солонгос	Нэгдээгүй	N/A	N/A
18	Польш	2017.06.07	2018.01.23	Тийм
19	Орос	2017.06.07	2019.10.01	Тийм
20	Сингапур	2017.06.07	2018.12.21	Тийм
21	Өмнөд Солонгос	2017.06.07	2020.09.07	Тийм
22	Швейцарь	2017.06.07	2019.12.01	Үгүй
23	Турк	2017.06.07	2018.01.01	Тийм
24	Украин	2018.07.23	2019.08.08	Тийм
25	Нэгдсэн Вант Улс	2017.06.07	2018.10.01	Тийм
26	Вьетнам	Нэгдээгүй	N/A	N/A

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

2025 оноос ОТК-ийн дагуу

Давхар татварын гэрээнд орох өөрчлөлтүүд



Холбоо барих

Серги Кобахидзе

Партнер

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

sergi.kobakhidze@pwc.com**Чойжамцын Цэндмаа**

Гүйцэтгэх Захирал

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

tsendmaa.choijamts@pwc.com**Жамбалын Энхзул**

Ахлах Менежер

Татварын зөвлөх үйлчилгээ

enkhzul.jambal@pwc.com**Эрдэнэ-Очирийн Энхсанаа**

Менежер

Татварын зөвлөх үйлчилгээ

enkhsanaa.erdene-ochr@pwc.com**ПрайсвотэрхаусКүүпэрс**

Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар

601 тоот, Улаанбаатар

14200, Монгол улс

Утас : + 976 70009089

Факс : +976 11 322068

www.pwc.com/mn

Та дээрх болон бусад асуудлаар татварын зөвлөх үйлчилгээ авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу.

**3. МУ-ын ОТХ-ийн заалтууд, хувилбаруудын хувьд хийсэн сонголтууд ба одоогийн ДТГ-нүүдэд үзүүлэх нөлөө**

ОТХ нь ТСБАШ төслийн 2, 6, 7, 14-р арга хэмжээнүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилготой 39 зүйлээс бүрддэг. Эдгээр арга хэмжээнд татварын зохицуулалтын зөрүү, гэрээг урвуулан ашиглах, төлөөний газар үүсгэхээс санаатайгаар зайлсхийх, болог олон улсын татварын маргааныг шийдвэрлэх зэрэг зарим чухал ТСБАШ асуудлууд багтсан байдаг.

Доорх хүснэгтэд ОТХ-ийн гол зүйлс, тэдгээрийн хувилбарууд дээр МУ-ын хийсэн сонголт болон тэдгээрийн одоогийн ДТГ-нүүдэд үзүүлэх боломжит нөлөөллийг товч танилцууллаа. Гэхдээ энд тухайлсан ДТГ-нд орох өөрчлөлтүүд нь оролцогч талуудын сонгосон байр суурийн уялдаа холбооноос хамаарна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм. Иймд, тодорхой ДТГ (жишээ нь, Хятад болон МУ-ын хоорондох ДТГ)-нд 2025 оноос эхлэн ОТХ-ийн хүрээнд орох өөрчлөлтийг нарийвчлан тодорхойлохын тулд тэдгээр оролцогч талууд (жишээ нь, Хятад болон МУ)-ын хийсэн сонголтуудыг харьцуулан шинжлэх шаардлагатай юм.

ОТХ-ийн зүйлийн нэр	Зүйлийн дугаар	ДТГ-д үзүүлэх боломжит нөлөөлөл:
Байнга оршин суугчийн давхар харьяалалтай этгээдүүд	4	Хэрэв татвар төлөгч хоёр улсын татварын оршин суугчийн шаардлагыг зэрэг хангасан бол ДТГ-ний хувьд оршин суугчийн статусыг харилцан тохиролцоо журам (ХТЖ)-аар тодорхойлно. ХТЖ-аар шийдэж чадаагүй тохиолдолд давхар оршин суугч этгээд ДТГ-ий өгөөжийг хүртэх эрхгүй.
Хамаарах татварын гэрээний зорилго	6	ДТГ нь татварын давхардал, татвараас зайлсхийх эсвэл зугтах явдлыг арилгах зорилготой болохыг илэрхийлсэн шинэ удиртгал текст нэмэгдэнэ.
Гэрээг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх (үндсэн зорилгын тест)	7(4)	Зөвхөн жинхэнэ оршин суугчид ДТГ-ний өгөөжийг эдлүүлэх зорилготой, гэрээний өгөөжийг хүртэх эрхийг тодорхойлох шалгууртай татвараас зайлсхийхийн эсрэг тусгай дүрэм ДТГ-нд нэмэгдэнэ.
Гэрээг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх (давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалт)	7(7)(a)	Илүү өргөн хүрээтэй, уян хатан татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм ДТГ-нд нэмэгдэнэ. Ингэснээр татварын албад тухайн ажил гүйлгээ, бүтцийн гол зорилго нь ДТГ-ний өгөөжийг хүртэх байсан тохиолдолд уг өгөөжийг эдлүүлэхээс татгалзах боломжтой болно.
Ногдол ашиг шилжүүлэх гүйлгээ	8	Ногдол ашиг шилжүүлэх гүйлгээнд хамаарах ДТГ-ний өгөөжийг хүртэхийн тулд хамгийн бага эзэмшлийн хугацаатай байхыг шаардсан татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм ДТГ-нд нэмэгдэнэ.
Этгээдийн үндсэн үнэлгээ нь үл хөдлөх хөрөнгөөс гаралтай хувь оролцоо, эсхүл хувьцаа шилжүүлсэнээс олсон хөрөнгийн	9(4)	Үл хөдлөх хөрөнгө, түүний дотор уул уурхайн эсвэл газрын эрхээс голчлон үнэ цэнэ нь бүрддэг этгээдийн хувьцааг борлуулсны олзтой холбоотой татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм ДТГ-нд нэмэгдэнэ.
Өөрийн оршин суугчид татвар ногдуулах аль нэг Оролцогч талын эрхийг хязгаарласан татварын гэрээг хэрэглэх	11(2)	Гэрээний зарим тусгай заалтаас бусад тохиолдолд тухайн улсын өөрийн оршин суугчдад татвар ногдуулах эрхийг ДТГ-ээр хязгаарлахгүй гэдгийг тодруулах "хамгаалалтын заалт" ДТГ-нд нэмэгдэнэ.
Тодорхой үйл ажиллагаанд хамаарах татварын чөлөөлөлтийг ашиглах замаар төлөөний газар үүсгэхээс санаатайгаар зайлсхийх	13	Үйл ажиллагаа нь зөвхөн "бэлтгэл эсвэл туслах шинж чанартай" тодорхойлолтод багтахгүй үйл ажиллагаануудыг илүү тодорхой болгосон заалтууд ДТГ-нд нэмэгдэнэ.

**Дүгнэлт:**

ОТХ-ийн хэрэгжилт ДТГ-ний хэрэглээнд ихээхэн нөлөө үзүүлэхээр байна. Иймд, татвар төлөгчид хил дамнанас үйл ажиллагаа, санхүүгийн болон эзэмшлийн бүтэц, зохицуулалт, гүйлгээгээ урьдчилан хянаж, шинэ дүрмүүдийн хэрэгжилтэд бэлтгэлтэй байх нь зүйтэй юм.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.